



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МОНОПОЛЫН ЭСРЭГ ГАЗАР

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 32 25, Факс: (976-11) 32 00 41,
Цахим шуудан: contact@ama.gov.mn,
Цахим хуудас: www.ama.gov.mn

2024.11.28 № 01/1979
танай _____-ны № _____-т

“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨҮГ-Т

ХАБ Халт оет

[Signature]
2024.11.29.

**Тендерийн баримт бичиг
хянасан тухай**

Танай үйлдвэрээс зарласан “CAT- 980H, CAT-980F автоачигчийн сэлбэг” МРЦМ/20240102161 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Альфа филтер” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хянан үзлээ.

Тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 1.3-т “Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бич: Байхгүй” гэж, мөн техникийн тодорхойлолтын “Багц 2: CAT980 серийн дугуйт ачигчийн сэлбэг” хэсэгт 1. Агаар шүүгч гадна, 2. Агаар шүүгч дотор, 3. Моторын маслын шүүр, 4. Түлшний шүүр, 5. Түлшний шүүр /тунгаах/, 6. Гидрийн шүүр, 7. Гидрийн шүүр, 8. Гидрийн банкны шүүр, 9. Хропны шүүр, 10. Кабины агаар шүүгч, 11. Агаар шүүгч /ТОМ/ гэж тус тус заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой чанар, стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрээс худалдан авахаар тендер шалгаруулалтын баримт бичигт заана” гэж, 8.2-т “Энэ хуулийн 8.1-д заасан барааны нэр, төрлийн жагсаалтыг эдийн засаг, хөгжлийн, хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран боловсруулж, Засгийн газар батална” гэж, 10 дугаар зүйлийн 10.4-т “Бараа худалдан авах тендер шалгаруулалт зохион байгуулахад энэ хуулийн 8.2-т заасан барааг бусад бараанаас тусад нь багцална” гэж, мөн Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт”-ын 14.8-д “Тоос, тоосонцор, хий, утаа шүүх, цэвэрлэх тоног төхөөрөмж, агаар шүүгч, тээврийн хэрэгслийн бүх төрлийн шүүлтүүр, тэдгээрийн сэлбэг эд, анги” гэж тус тус заасан байна.

Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичгийг боловсруулахдаа дотоодын үйлдвэрээс худалдан авах боломжтой бараа бүтээгдэхүүнийг бусад бараа бүтээгдэхүүнээс тусад нь багцлаагүй, мөн тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 1.3-т дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байхгүй гэж заасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт, 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт заасныг тус тус зөрчсөн байна.

152400300936

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5.2 дахь заалтад заасны дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт холбогдох өөрчлөлт оруулж хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу мэдэгдсэний үндсэн дээр тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг даалгаж байна.

ДАРГА



Б.БИЛГҮҮН